

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ҮР ДҮНГИЙН
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

(2016 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар)

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

Д/Д	Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)	Хариуцах газар, алба	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Өгсөн үнэлгээ (0-30 оноо)
1	2	3	4	5
1.	1.3.1.Иргэний нисэхийн бус нийтлэг үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар үе шаттайгаар гүйцэтгүүлэх хөтөлбөр боловсруулж, батлуулна. Зорилтот түвшин: Хөтөлбөрийг боловсруулан, холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулсан байна. Хугацаа: 1-8 сар	ХЭЗГ АТЭЗЗГХАГ	"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэний нисэхийн нийтлэг үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх" зорилтыг хэрэгжүүлэх асуудлыг судлан дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна. Иргэний нисэхийн нийтлэг үйлчилгээний төрлийн жагсаалтыг гарган, өмчийн хэлбэр, эдийн засгийн байдал, тухайн чиглэлийн өрсөлдөөний талаар судалгаа хийж байна. <i>/Хэрэгжилт- 10%/</i>	3
2.	2.4.1.“Аэродромын төлөвлөлт, ашиглалт, арчлалтын стандарт” боловсруулан батлуулна. Зорилтот түвшин: Үндэсний стандарттай болсон байна. Хугацаа: 1-11 сар	НБУГ	Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцийн хавсралт-14 /Annex-14/-ийг Монгол улсын MNS стандартын тогтолцоонд оруулж нутагшуулах зорилгоор “Аэродром төлөвлөлт, ашиглалт”-ийн стандартыг боловсруулахаар судалгаа хийж байна. <i>/Хэрэгжилт- 10%/</i>	3
3.	2.4.2. “Нисэхийн шатахууны чанарын хяналт ба шатахууны сумалгааны үйл ажиллагааны стандарт”-ыг боловсруулж, батлуулна. Зорилтот түвшин: Үндэсний стандарттай болсон байна. Хугацаа: I улирал	НААХЗГ	Стандартчилал хэмжилзүйн газарт “Агаарын хөлгийн шатахууны чанарын хяналт ба сумалгаа хийх үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандартыг Стандартын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2016.04.28-ний 19 дүгээр тогтоолоор батлуулсан. <i>/Хэрэгжилт- 100%/</i>	30
4.	3.1.1.Иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэгчдийн гэрчилгээжилт, хувь хүний үнэмлэхжүүлэлтээр салбарын үйл ажиллагаанд тогтмол аудит, хяналт тавина. Зорилтот түвшин: Агаарын хөлгийн бүртгэлд бүртгэсэн байна. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын 17 гэрчилгээг сунгасан байна. ИНД-119-ийн дагуу 3 агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг, ИНД-129-ийн дагуу 2 гадаадын тээвэрлэгчийн гэрчилгээг, ИНД-301-ийн дагуу 1 ачааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг тус тус сунгасан байна. Агаарын хөлгийн техник үйлчилгээний дотоодын 7, гадаадын байгууллагаас хүсэлт ирүүлсний дагуу гэрчилгээ олгоно.	НААХЗГ	- Аэродромын гэрчилгээ олголт 1. Дундговь аймаг дахь ИНЕГ-ын харьяа “Мандалговь” нисэх буудалд олгогдсон Аэродромын түр зөвшөөрлийн хугацааг 2017 оны 3-р сарын 28-ны өдөр хүртэл 1 жилээр сунгаж олгосон. 2. Өмнөговь аймгийн Ханбогд суман дахь "Ханбумбат" нисэх буудлын Аэродромын гэрчилгээг ИНД139-ын дагуу 1 жилээр сунгасан. 3. Өмнөговь аймгийн “Гурван сайхан” нисэх буудлын Аэродромын гэрчилгээний хугацааг 2018 оны 5-р сарын 31-ний өдөр хүртэл 2 жилээр сунгаж олгосон. 4. Хөвсгөл аймаг дахь “Мөрөн” нисэх буудлын Аэродромын гэрчилгээг 2017 оны 5–р сарын 31-ний өдөр хүртэл 1 жилээр сунгаж олгосон. - Агаарын хөлгийн бүртгэл, НТЧ гэрчилгээ олголт	27

	<p>Сургалтын 3 байгууллагын гэрчилгээг сунгасан байна. Орон нутгийн 14 нисэх буудлын гэрчилгээний хугацааг сунгана</p> <p>Нисгэгч, нисгэгчээс бусад нисэх багийн гишүүдийн үнэмлэх сунгалт-100; Агаарын хөдөлгөөний үйлчилгээний ажилтан /нислэгийн удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтан/-195;</p> <p>Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийн сунгалт-95;</p> <p>Эрүүл мэндийн гэрчилгээний сунгалт- гэрчилгээ олголт-260;</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>		<ol style="list-style-type: none"> 1. “А-Жет Авиэйшн” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу JU-5499, JU-5598 бүртгэлийн дугаартай МВВ-ВК 117С-2 маягийн нисдэг тэргүүдийг “РЕО БАЯНХОНГОР” ХХК-ийн нэр дээр 16.03.16-д бүртгэж, бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан. 2. “АэроМонголиа” ХХК-ийн JU-8251, JU-8258 бүртгэлийн дугаартай Fokker-50 маягийн агаарын хөлгүүдийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 3. Хүннү Эйр ХХК-ийн JU-8882 бүртгэлийн дугаартай Fokker-50 маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 4. “Блу Скай Авиэйшн” ХХК-ийн JU-2114 бүртгэлийн дугаартай Cessna-208В маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр тус тус сунгасан. <p>- Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ :</p> <ol style="list-style-type: none"> 1. KAL Сургалтын байгууллагын гэрчилгээ /2020.11.23/ , Үйл ажиллагааны тодорхойлолтыг 2 жилээр, 2. Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг сунгасан. 3. “Boeing” сургалтын байгууллагын гэрчилгээ /2021.02.05/, Үйл ажиллагааны тодорхойлолтыг 2 жилээр, 4. SATC сургалтын байгууллагын гэрчилгээ /2021.02.15/, 5. МИАТ сургалтын төв /2020.01.15/, Үйл ажиллагааны тодорхойлолтыг 2 жилээр. <p>- Мэргэжлийн үнэмлэх олголт, сунгалт</p> <ol style="list-style-type: none"> 1. Нисгэгч, нисгэгчээс бусад нисэх багийн гишүүдийн үнэмлэх сунгалт-12, шинээр үнэмлэх олгосон-3, 2. Агаарын хөдөлгөөний үйлчилгээний ажилтан /нислэгийн удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтан/-29, шинээр үнэмлэх олгосон-5, шинээр зэрэглэл олгосон-12, 3. Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийн сунгалт-16, шинээр үнэмлэх олгосон-2, шинээр зэрэглэл олгосон-2, 4. Эрүүл мэндийн гэрчилгээний сунгалт- гэрчилгээ олголт-70. <p>- Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, зөвшөөрөл</p> <ol style="list-style-type: none"> 1. А-Жет Авиэйшн ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу JU-5499, JU5598 бүртгэлийн дугаартай МВВ-ВК 117С-2 маягийн нисдэг тэргүүдийг РЕО БАЯНХОНГОР ХХК-ийн нэр дээр 16.03.16-д бүртгэж, бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан. 2. Топ Экстрим Экшин Монголиа ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Calidus маягийн агаарын хөлгийг JU-9003, Cavalon маягийн агаарын хөлгийг JU-9005 дугаартайгаар Монгол Улсад бүртгэсэн. 3. Сэлиэр Авиэйшн Монголиа ХХК - иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Xenon 4 маягийн агаарын хөлгийг JU-9009 дугаартайгаар Монгол Улсад бүртгэсэн. 4. АэроМонголиа ХХК-ийн JU-8251, JU-8258 бүртгэлийн дугаартай Fokker-50 маягийн агаарын хөлгүүдийн НТЧ-ын гэрчилгээг 1 	
--	---	--	---	--

			<p>жилээр,</p> <ol style="list-style-type: none"> 5. Хүннү Эйр ХХК-ийн JU-8882 бүртгэлийн дугаартай Fokker-50 маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 6 сараар, 6. Блу Скай Авиэйшн ХХК-ийн JU-2114 бүртгэлийн дугаартай Cessna-208В маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 7. МИАТ ХК-ийн JU-1011 бүртгэлийн дугаартай B767-300, JU-1015 бүртгэлийн дугаартай B737-800 маягийн агаарын хөлгүүдийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 8. МАК ХХК-ийн JU-6600 бүртгэлийн дугаартай Ми-8АМТ маягийн нисдэг тэрэгний НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 9. Геосан ХХК-ийн JU-9991, JU-9993 бүртгэлийн дугаартай Cessna-208В маягийн агаарын хөлгүүдийн НТЧ-ын гэрчилгээг 1 жилээр, 10. Томас Эйр ХХК-ийн JU-1919 бүртгэлийн дугаартай Maule M7-235С маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 1 сараар, 11. Голд Васт Интерпрайс ХХК-ийн JU-9069 бүртгэлийн дугаартай Ан-2 маягийн агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг 3 сараар тус тус сунгасан. <p><u>- Техник үйлчилгээни байгууллагын гэрчилгээ олголт:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. МИАТ ХК-ийн ТҮБ-ын гэрчилгээний хүчинтэй хугацааг 1 жилээр, Хүннү Эйр ХХК-ийн ТҮБ-ын гэрчилгээг 1 жилээр, 2. АэроМонголиа ХХК-ийн ТҮБ-ын гэрчилгээг 1 жилээр тус тус сунгасан. 3. Герман Улсын NAYAK байгууллагын ТҮБ-ын гэрчилгээг 1 жилээр, 4. Испани Улсын Industria De turbopropulsores S.A байгууллагын ТҮБ-ын гэрчилгээг 1 жилээр, 5. Нидерланд Улсын Standard AERO B.V байгууллагын ТҮБ-ын гэрчилгээг 1 жилээртус тус сунгасан. <p><u>- Гадаадын Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ :</u></p> <ol style="list-style-type: none"> 1. ИНД-129 дүрмийн дагуу Эйр Бусан компанид үзлэг шалгалт хийж гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгосон. 2. Эйр Астана компанид шинээр гэрчилгээ олгох үзлэг шалгалт хийгдэж нэгдсэн дүгнэлт гаргасан. 3. Tianjing Airlines компанид шинээр гэрчилгээ олгох үзлэг шалгалт хийгдэж байна. <p><u>- ИНД-140-ийн дагуу:</u> Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудалд ИНД-140-ийн хүрээнд олгогдсон №140-07 дугаартай Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг 1 жилээр сунгаж, байцаагчийн дүгнэлтийн хамт 2016.05.13-ны 02/б/1617 тоот албан бичгээр хүргүүлэв.</p> <p><u>- ИНД-171-ийн дагуу:</u> ТХНҮА-аас 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08/б/946 тоотоор ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу үзлэг шалгалт хийсэн байцаагчийн дүгнэлтийг үндэслэж, тус албаны №171-01 дугаартай гэрчилгээнд "ADS-B үйлчилгээ"-ний төрлийг нэмж тусган,</p>	
--	--	--	--	--

			<p>байцаагчийн дүгнэлтийн хамт 2016 оны 3-р сарын 03-ны 02/б/611 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- ИНД-172-ын дагуу: Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас ирүүлсэн ИНД-172-ын дагуу олгогдсон гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах хүсэлт, өргөдөл болон Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн үзлэгийн шалгалтын 2016 оны төлөвлөгөөний дагуу тухайн байгууллагын нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн хүрээнд 5-р сарын 24-нөөс 27-ны өдрүүдэд аудит шалгалт хийж, байцаагч нарын нэгдсэн дүгнэлт гаргасан. Нэгдсэн дүгнэлтийг үндэслэн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны гэрчилгээний хугацааг ИНД-172-ын дагуу 1 жилээр сунгаж олгосон.</p> <p>- ИНД 173-ын дагуу: 2016 оны НААХЗГ-ын үзлэг шалгалтын хуваарийн дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд Шалгалтын нислэг, зураглалын албанд ИНД-173-аар олгогдсон Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага"-ын гэрчилгээний хугацааг сунгах үзлэг шалгалтыг 2016 оны 4-р сарын 18-наас 22-ны өдрүүдэд гүйцэтгэсэн байцаагчийн нарын дүгнэлтийг үндэслэн Шалгалтын нислэг, зураглалын албаны Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг 2019 оны 4-р сарын 25-ны өдөр хүртэл сунгасан.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	
5.	<p>3.1.2.Иргэний нисэхийн багц дүрмийн шинэчлэл, сайжруулалтай холбоотойгоор иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.</p> <p>Зорилтот түвшин: Хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	НААХЗГ		0
6.	<p>3.1.3.Иргэний нисэхийн хяналтын дотоод үйл ажиллагааны чанар баталгаажилтыг бий болгож, хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилтот түвшин: Дотоод хяналтын үйл ажиллагаа сайжирсан байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	НААХЗГ	<p>ИНЕГ-ын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/10 дугаар тушаалаар Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газарт дотоод хяналт хариуцсан 2 орон тоог бий болгосон. Иргэний нисэхийн хяналтын дотоод үйл ажиллагааны чанар баталгаажилтын чиглэлээр энэ онд хийх ажлын төлөвлөгөөг 3 дугаар сард баталж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт- 70%/</i></p>	21
7.	<p>3.2. АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулж, энэ чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.</p>	НААХЗГ	<p>ИНЕГ-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/160 дугаар тушаалаар АСЕМ-ийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг томилж, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж байна. Нисэхийн аюулгүй байдлыг чангатгах дотоод сургалт, танилцуулга</p>	21

	<p>Зорилтот түвшин: АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: 1-7 сар</p>		<p>хийж, шалгагч нарын онолын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх шаталсан сургалтуудыг явуулж байна.</p> <p><i>/хэрэгжилт- 70%/</i></p>	
8.	<p>4.1.4.БНСУ, Тайландын Вант Улсын талтай агаарын харилцааны хэлэлцээ хийнэ. Зорилтот түвшин: Хэлэлцээ хийсэн байна. Хугацаа: 1-11 сар</p>	АТЭЗЗГХАГ	<p>1. БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан Солонгос-Монголын хамтын ажиллагааны форумын үеэр хоёр улсын тээвэр хариуцсан сайд нарын уулзалтаар Монголын агаарын тээвэрлэгчийн Чөжү-Бээжин-Чөжү чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрхтэйгээр нислэг үйлдэх асуудлыг нисэхийн удирдах байгууллага хооронд хэлэлцэх, улмаар уг асуудлаар Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах талаар урьдчилсан байдлаар тохирсон болно. Үүний дагуу хоёр улсын нисэхийн удирдах байгууллага хоорондын зөвлөлдөх уулзалтуудыг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны болон 28-ны өдрүүдэд Монгол Улс, БНСУ-д ээлжлэн зохион байгуулж, Харилцан ойлголцлын санамж бичгийн төслүүдийг солилцоод байна. БНСУ-ын тал Сөүл-Улаанбаатар чиглэлд олон агаарын тээвэрлэгч нислэг гүйцэтгэх боломж бүрдүүлэх, нислэгийн давтамжийг 10 болгон нэмэгдүүлэх зэрэг санал ирүүлсэн тул хоёр тал тодорхой тохиролцоонд хүрээгүй байна. Чөжү муж нь чөлөөт бүс тул Монголын талаас Чөжү-Бээжин-Чөжү чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрхтэйгээр нислэг үйлдэх асуудлыг хоёр талын Агаарын харилцааны хэлэлцээрийн хүрээнд оруулахгүйгээр тохирох саналтай байгаагаа илэрхийлээд байна. БНСУ-ын талаас шийдвэрлэгдээгүй асуудлуудыг нэг мөр болгохоор Монгол-Солонгосын 2 талт уулзалтыг 06 дугаар сарын сүүлээр эсвэл 07 дугаар сарын эхээр хийх саналыг 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн бөгөөд Монголын тал энэхүү уулзалтыг энэ оны 07 дугаар сарын сүүлийн 10 хоногт Сөүл хотноо хийх саналаа 05 дугаар сарын 31-ний өдөр ИНЕГ-ын 01/114 тоот албан бичгээр БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яаманд хүргүүлээд байна.</p> <p>2. Тайландын Вант Улстай Бүгд Найрамдах Доминик Улсад зохион байгуулагдах ICAN 2016 хурлын үеэр агаарын харилцааны хэлэлцээ хийхээр төлөвлөж байна.</p> <p><i>/хэрэгжилт- 50%/</i></p>	15
9.	<p>4.2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагаа, үйлчилгээний менежментийг сайжруулах судалгаа хийж, санал боловсруулна. Зорилтот түвшин: Санал боловсруулж, ИНЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулсан байна. Хугацаа: I улирал</p>	НБУГ	<p><i>/хэрэгжилт-0%/</i></p>	0

10.	5.1.1.Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын "Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Зорилтот түвшин: Хэлэлцээрийн төслийг тохирсон байна. Хугацаа: 1-12 сар	НХУГ	Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын "Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан 2015 оны 01 дүгээр сарын 20-ны 01/124 албан тоот бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. <i>/хэрэгжилт-0%/</i>	0
11.	5.2.1.Улсын нисэх болон Иргэний нисэхийн хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөрийг батлуулна. Зорилтот түвшин: Хөтөлбөр батлагдсан байна. Хугацаа: 1-11 сар	НХУГ	"Иргэний нисэх, улсын нисэх хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг шинэчлэн боловсруулж ИНЕГ-ын даргын 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 02/2901 тоот албан бичгээр Батлан хамгаалах яамны Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалд хүргүүлсэн. Батлан хамгаалах яамны Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалаас өнөөг хүртэл хариу ирүүлээгүй байна. Энэхүү хөтөлбөрийг батлуулах, холбогдох хариуг авах талаар НХУГ-ын менежер Н.Доржсүрэн 2016 оны 05 дугаар сард Батлан хамгаалах яамны Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын Ерөнхий командлагч н.Энхбаяртай ажил хэргийн уулзалт хийж энэ асуудлын талаар 2016 оны 06 дугаар сард багтаан дахин уулзалт зохион байгуулахаар тохиролцсон. Тус уулзалтыг ИНЕГ дээр зохион байгуулах саналыг тавьсан болно. <i>/хэрэгжилт30%/</i>	9
12.	5.3.1.Хоёр дахь нислэг хөдөлгөөн удирдах төвийн аэронавигацийн үйлчилгээний тоноглолын техникийн даалгаврыг нарийвчлан боловсруулна. Зорилтот түвшин: Техникийн даалгаврыг батлуулан, хөрөнгийг 2017 оны төсөвт суулгах арга хэмжээ авсан байна Хугацаа: 1-12 сар	НХУГ	Улаанбаатар бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын шинэ төвийг агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжөөр тоноглох ажилд тавигдах шаардлагыг боловсруулсан. Хэлэлцүүлэг зохион байгуулах, баталгаажуулах, түүний үндсэнд техникийн даалгавар боловсруулах ажил хийгдэж байна. <i>/хэрэгжилт-50%/</i>	15
13.	5.3.2. Чикагогийн конвенцийн хавсралт 15, ISO 19100 серийн стандарт, шаардлагуудыг хангасан НМҮА-ны автомат системүүдийн өгөгдлийг бүрдүүлэх газрын гадарга болон саадын өгөгдлийн сан, аэродромын зураглалын өгөгдлийн санг бүрдүүлнэ. /Хөшигийн хөндий/ Зорилтот түвшин: Хөшигийн хөндийн нисэх буудлын газрын гадарга болон саадын өгөгдлийн сантай болсон байна. Хугацаа: II -III улирал	НХУГ	Хөшигийн Хөндий орчмын газрын гадарга болон саадын өгөгдлийн сан бүрдүүлэх ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог томилж, ажиллаж байна. <i>/хэрэгжилт- 30%/</i>	9
14.	5.4.1. Монгол Улсын агаарын зайд Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн /PBN/ төлөвлөгөөний хоёр дах шатыг хэрэгжүүлнэ. Зорилтот түвшин: 2016 онд хийхээр төлөвлөсөн ажил бүрэн хийгдсэн байна.	НХУГ	Төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажил хийгдэж байна. 2016 оны 2 дугаар сард ХБНГУ-ын DFS байгууллагын мэргэжилтэнүүдтэй хамтран агаарын зайн төслийг боловсруулсан бөгөөд Агаарын зайн агаарын навигацийн өгөгдөлийн тооцоолол хийгдсэн. Холбогдох аюулгүй ажиллагааны үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэхүү үе шатыг хэрэгжүүлсэнээр Монгол	15

	Хугацаа: 1-12 сар		Улсын нутаг дэвсгэрийн дагуу агаарын хаалганаас хаалганд, нисэх буудлаас буудалд чиглэсэн үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замуудыг тогтоон агаарын тээвэрлэгчид болон байгал орчинд ээлтэй байх чухал ач холбогдолтой юм. Төлөвлөгөөний дагуу 2016 оны 09 дүгээр сард нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэхээр төлөвлөж, холбогдох бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж байна. <i>/хэрэгжилт-50%/</i>																											
15.	5.4.2.Монгол Улсын агаарын зайд багагасан босоо зайчлалын футын систем /RVSM feet FLOS/-ийг нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангах төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авна. Зорилтот түвшин: 2016 онд хийхээр төлөвлөсөн ажил бүрэн хийгдсэн байна. Хугацаа: 1-12 сар	НХУГ	Тус системийг нэвтрүүлэх талаар холбогдох судалгаанууд хийгдэж байгаа бөгөөд хөрш орнуудтай харилцан зөвшилцөх ажил хийгдэж байна. Дараах шалтгаануудын улмаас энэхүү үйл ажиллагааг 2016 онд хэрэгжүүлэх боломжгүй болсон тул түр хойшлуулаад байна. Үүнд: 1. БНХАУ-н талтай өндрийн шилжилтийн бүсүүдийг тогтооход зөвшилцөх шаардлагатай байгаа бөгөөд одоогийн байдлаар БНХАУ-ын зүгээс бүсүүдийг өөрийн улсдаа авахгүй байх зарчимтай байгаагаар урьдчилан мэдэгдээд байна. Энэхүү зөвшилцөлийг нааштайгаар хийн зарим агаарын хаалгануудын өндрийн шилжилтийн бүсийг БНХАУ-ын талд хийхээр дараа дараагийн зөвшилцөх уулзалтууд зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байна. 2. Футын системд шилжсэнээр үүсч болох аюулгүй ажиллагааны эрсдэлийн үнэлгээг олон улсын байгууллагуудтай хамтран хийх ажлуудыг зохион байгуулж байна. <i>/Дүгнэх боломжгүй/</i>	-																										
16.	5.4.3.Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч, бууж буй агаарын хөлөгт агаарын навигацийн болон агаарын хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ. Зорилтот түвшин: Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч бууж буй агаарын хөлөгт агаарын навигацийн болон агаарын хөдөлгөөний үйлчилгээ үзүүлсэн байна. Хугацаа: 1-12 сар	НХУГ	2016 оны 5-р сарын 15-ны байдлаар нийт 78159 нислэг төлөвлөж, 37058 нислэг гүйцэтгэгдсэн байна. <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Нислэгийн төрөл</th> <th>Төлөвлөлт</th> <th>Гүйцэтгэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="3">1</td> <td>Олон улсын өнгөрөлт</td> <td>74181</td> <td>33786</td> </tr> <tr> <td>Үүнээс: нөөц төлөвлөлтөөр</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Үндсэн төлөвлөлтөөр</td> <td>74181</td> <td>33786</td> </tr> <tr> <td>2</td> <td>Олон улсын хөөрөлт,буулт</td> <td>2220</td> <td>1980</td> </tr> <tr> <td>3</td> <td>Орон нутгийн хөөрөлт,буулт</td> <td>1758</td> <td>1292</td> </tr> <tr> <td colspan="2">Дүн:</td> <td>78159</td> <td>37058</td> </tr> </tbody> </table> <i>/хэрэгжилт- 90%/</i>	№	Нислэгийн төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл	1	Олон улсын өнгөрөлт	74181	33786	Үүнээс: нөөц төлөвлөлтөөр			Үндсэн төлөвлөлтөөр	74181	33786	2	Олон улсын хөөрөлт,буулт	2220	1980	3	Орон нутгийн хөөрөлт,буулт	1758	1292	Дүн:		78159	37058	27
№	Нислэгийн төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл																											
1	Олон улсын өнгөрөлт	74181	33786																											
	Үүнээс: нөөц төлөвлөлтөөр																													
	Үндсэн төлөвлөлтөөр	74181	33786																											
2	Олон улсын хөөрөлт,буулт	2220	1980																											
3	Орон нутгийн хөөрөлт,буулт	1758	1292																											
Дүн:		78159	37058																											
17.	5.5.1.ОХУ болон Монгол улсын хооронд нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт SAREX-2016 олон улсын хамтарсан сургуулалтыг зохион байгуулж, оролцоно.	НХУГ	Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 6 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилуулсан. Ажлын хэсгийн анхдугаар хурлыг энэ оны 04 дүгээр сарын 08-ны өдөр	21																										

	<p>Зорилтот түвшин: 2 Улсын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу сургалт зохион байгуулж, эрэн хайх, авран туслах чиглэлээрх хамтын ажиллагаа сайжирсан байна. Хугацаа: 9 сар</p>		<p>Төрийн ордонд зохион байгуулж, Хамтарсан сургуулилтыг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөг, ажлын хэсгийн баримтлах ажлын удирдамжийг тус тус баталсан. Сургуулилтыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах ажлын албыг ИНЕГ-ын хэмжээнд байгуулан хөтөлбөр, зохиомж, зохиомжийн дагуу нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулав. Энэ оны 06 дугаар сарын 30-аас 07 дугаар сарын 01-ны хооронд ОХУ-тай Улаанбаатар хотноо зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. /БНХАУ-ын тал ажиглагчаар, оролцогчоор эсэхээ шийдээгүй байна. /Ажлын хэсгийн хурлын шийдвэрээр сургуулилтыг Өвөрхангай аймгийн Элсэн тасархай бүс нутагт энэ оны 08 дугаар сарын 23-аас 26-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтов. <i>/хэрэгжилт-70%/</i></p>	
18.	<p>6.2.1.Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг үргэлжлүүлнэ. Зорилтот түвшин: Барилгын ажлыг дуусгасан байна. Хугацаа: 1-12 сар</p>	НБУГ	<p>Говь-Алтай аймгийн нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвасын аэродромын барилга угсралтын ажлыг 2016.04.15-аас эхлүүлсэн. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр болох 451,9 сая төгрөгийг Зам, тээврийн сайдын 2016 оны 05-р сарын 20-ны өдрийн 191 дүгээр тушаалаар шийдвэрлүүлсэн. Мөн нэмэлт гэрээний төслийг 2016 оны 05 сарын 31-ний өдрийн 01/1818 тоот албан бичгээр ЗТЯ-аар батлуулахаар хүргүүлээд байна. <i>/хэрэгжилт- 50%/</i></p>	15
19.	<p>6.3.1.Орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийнэ. Зорилтот түвшин: Нисэх буудлуудын зэрэглэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай, техник тоног төхөөрөмж, зурвасын даац, ангиллын талаар судалгаа хийгдсэн байна. Хугацаа: I-II улирал</p>	НБУГ	<p>Орон нутгийн нисэх буудлуудын зурвасын даац, ангиллын талаар судалгааг хийж шинэчлэн Нислэгийн мэдээллийн эмхэтгэлд бүртгүүлж зарлуулж байна. Мөн барилга байгууламжуудын хүчин чадлын судалгаа, техник тоног төхөөрөмжийн судалгаануудыг нэгтгэн гаргасан. <i>/хэрэгжилт-90%/</i></p>	27
20.	<p>6.4.1 Олон улсын шинэ нисэх буудал, түүний дагуул хотын Засаг захиргааны харъяаллын асуудлын хууль, эрх зүйн орчныг тодорхой болгож шийдвэрлэх “Улаанбаатарын Олон улсын шинэ нисэх буудал” статусыг олгуулах. Зорилтот түвшин: Холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Хугацаа: 1-11 сар</p>	НБУГ	<p>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах бэлтгэлийг хангах, нисэх буудлуудын үйл ажиллагааг эхлүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд “Улаанбаатарын Олон улсын шинэ нисэх буудал” статусыг олгуулах ажил тусгагдсан ба одоогоор ажил эхлэх шатандаа явж байна. <i>/хэрэгжилт-10%/</i></p>	3
21.	<p>6.4.2.Нисэх буудлын менежментийг концессоор хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. Зорилтот түвшин: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Хугацаа: 1-11 сар</p>	НБУГ	<p>Шинэ нисэх буудлын үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх “Концесс эзэмшигч”-ийг шалгаруулах техникийн даалгаврыг боловсруулж 2016 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр, санхүүгийн даалгаврын боловсруулж 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус тус Концессийн ажлын хэсэг болон ЗТЯ-нд хүргүүлсэн. ИНЕГ, ЗТЯ, Агаарын тээвэрлэгчдийн холбоо, Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран концессийн санал авах урилгын талаарх тодруулгад санал өгч ЗТЯ-нд хүргүүлсэн. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг хэрэгжүүлэхэд</p>	21

			шаардлагатай санхүү болон хуулийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулсан бөгөөд батлуулах шатандаа явж байна. <i>/хэрэгжилт-70%/</i>	
22.	6.4.3.“Чингис хаан” олон улсын нисэх буудлыг шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна. Зорилтот түвшин: Төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Хугацаа: 1-11 сар	НБУГ	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах бэлтгэлийг хангах, нисэх буудлуудын үйл ажиллагааг эхлүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд байгууллага тус бүрийн нүүлгэн шилжүүлэх дэд төлөвлөгөөнүүд багтсан бөгөөд ЗТЯ, ИНЕГ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, “Чингис хаан” ОУНБ зэрэг байгууллагуудын саналыг авч нэгтгэн 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Ашиглалтын өмнөх удирдах хороо болон ЗТЯ-аар батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу агаарын тээвэрлэгч болон хилийн хяналтын байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, НБУГ-ын дарга бөгөөд Ерөнхий координатороор 2016 оны 5 дугаар сарын 13-нд батлуулсан. <i>/хэрэгжилт-30%/</i>	9
23.	6.4.4.“Чингис хаан” олон улсын нисэх буудлыг цаашид ашиглах талаар санал боловсруулан шийдвэрлүүлнэ. Зорилтот түвшин: Шийдвэр гаргуулсан байна. Хугацаа: 1-6 сар	НБУГ	“Зам, тээврийн сайдын зөвлөлийн 2016 оны өдрийн 02 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар “Чингис хаан” ОУНБ-ыг цаашид ерөнхий нисэхийн чиглэлээр үргэлжлүүлэн ашиглаж, нэршлийг “Буянт-Ухаа” Аэродром болгон өөрчлөх шийдвэр гарсан. <i>/хэрэгжилт-100%/</i>	30
24.	6.5.1. Орон нутгийн зарим нисэх буудлын барилга, зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих боломжийг бүрдүүлж, холбогдох стандартад нийцүүлнэ. Зорилтот түвшин: Судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, холбогдох стандартад нийцүүлэх ажлыг эхлүүлсэн байна. Хугацаа: I-IV улирал	НБУГ	Орон нутгийн нисэх буудлуудын барилга, зам талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээ, тоног төхөөрөмжийг хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг ИНЕГ-ын даргаар батлуулан 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/772 тоот албан бичгээр ЗТЯ-ны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэст хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний дагуу 2016 онд хийгдэх ажлуудыг ИНЕГ-ын 2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан боловч энэхүү ажлын санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй. Иймд холбогдох ажлуудыг 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна. <i>/хэрэгжилт-50%/</i>	15
25.	7.1.1.Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гаргаж, ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах арга хэмжээ авна. Зорилтот түвшин: Гадаад, дотоод 2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох ажилтнуудыг сургалтад хамруулсан байна. Хугацаа: 1-12 сар	ЗУГ, НСТ	ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтад эхний хагас жилийн байдлаар нийт 804 ажилтан хамрагдсан болно. Үүнд: Нисэхийн сургалтын төвийн нийт 35 сургалтад 721 ажилтан, гадны байгууллагуудын нийт 22 сургалтад 83 ажилтнууд тус тус хамрагдав. <i>/хэрэгжилт-90%/</i>	27
26.	7.1.2. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад иргэний	ЗУГ	ИНЕГ-ын зардлаар 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн	30

	<p>нисэхийн шаардлагатай нарийн мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэнэ</p> <p>Зорилтот түвшин: Хэрэгцээ шаардлагатай мэргэжлээр ажилтнуудыг бэлтгэсэн байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>		<p>байдлаар нийт 32 мэргэжлээр 12 улс оронд нийт 114 оюутан суралцаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-100%/</i></p>	
27.	<p>8.1.1. Монгол Улсын 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтаар болон ИНЕГ-ын өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилтот түвшин: Төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	СЭЗГ	<p>Монгол Улсын 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Зам тээврийн сайдын 2016 оны 10 дугаар тушаалаар Ази-Европын дээд түвшний 11-р уулзалт (ASEM)-ын чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах зориулалттай ИНЕГ-ын 2016 оны тоног төхөөрөмжийн жагсаалт бүхий 43 төсөл арга хэмжээ батлагдаж хэрэгжүүлж байна. Үүнээс: 2 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 14 төсөл арга хэмжээ гэрээ байгуулагдаж, ажил гүйцэтгэж байна, 3 байгууллагад гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн, 16 төсөл арга хэмжээний тендерийг нээсэн Үнэлгээний хороо үнэлж байна, 8 тендерийн зарлан нээсэн боловч амжилтгүй болж шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул Үнэлгээний хороо хуралдаж байна.</p> <p>ИНЕГ-ийн өөрийн хөрөнгөөр буюу 2013 оны цэвэр ашгийн хөрөнгөөр 21 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаагаас 20 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 1 төсөл арга хэмжээ амжилтгүй болсон байна.</p> <p>ИНЕГ-ийн өөрийн хөрөнгөөр буюу 2014 оны цэвэр ашгийн хөрөнгөөр нийт 26 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 21 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, хүлээж авч байгаа 1 төсөл арга хэмжээ, хэрэгжиж байгаа 4 төсөл арга хэмжээ тус тус байна.</p> <p>ИНЕГ-ийн өөрийн хөрөнгөөр буюу 2015 оны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээ Зам тээврийн сайдын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 156 дугаар тушаалаар батлагдсан, хэрэгжиж эхэлж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-50%/</i></p>	15
28.	<p>8.1.2.ИНЕГ-ын 2016 оны бараа ажил, үйлчилгээ худалдан авалтын биелэлтийн ерөнхий тайлан, мэдээг Зам, тээврийн яам болон Сангийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байрлуулна.</p> <p>Зорилтот түвшин: Мэдээлэл нийтийн хүртээл болсон байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	СЭЗГ	<p>ИНЕГ-ын 2016 оны бараа ажил, үйлчилгээ худалдан авалтын биелэлтийн 1-5-р сарын ерөнхий тайлан, мэдээг Зам, тээврийн яам болон Сангийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-9%/</i></p>	27
29.	<p>9.1.1.Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон (ICAO) –ын дэмжлэгтэйгээр бүс нутагт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд (COSCAP-NA, CASP-AP, FPP, TRAIN AIR PLUS, CAPSCA) идэвхитэй оролцоно.</p>	АТЭЗЗГХАГ	<p>1/ <u>CASP-AP хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд:</u> ICAO-ын CASP-AP хөтөлбөртэй хамтран 2016 оны 5-дугаар сарын 06-ны өдөр Нисэхийн аюулгүй байдлын байцаагчийн гарын авлага сэдвээр “Чингис Хаан” ОУНБ, “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, НБУГ-ын холбогдох мэргэжилтэн, байцаагч нарыг хамруулан</p>	27

	<p>Зорилтот түвшин: Хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцож өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна Хугацаа: 1-12 сар</p>		<p>семинар зохион байгуулсан.ИНЕГ-ын даргын 2016 оны А172 дугаар тушаалын дагуу ИНЕГ-аас ICAO-ийн CASP-AP хөтөлбөртэй хамтран 2016 оны 5 дугаар сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд “Агаарын ачаа ба шуудангийн аюулгүй байдал” сэдэвт олон улсын сургалтыг томилогдсон Ажлын хэсэг амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтад Филиппин улсаас 3 төлөөлөгч, манай улсаас НААХЗГ, НБУГ, “Чингис хаан” ОУНБ, “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-аас оролцон, нийт 16 оролцогч хамрагдсан. 2/ <u>COSCAP-NA хөтөлбөрийн хүрээнд:</u> COSCAP-NA хөтөлбөрийн техникийн туслалцааны хүрээнд 2016 оны 4 дүгээр сарын 11-15-ны хооронд ажилтнуудад Албадлагын арга хэмжээний зааврыг шинэчлэн боловсруулах, Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны эрсдэлийн үнэлгээ хийх талаар сургалт, зөвлөмж өгч ажлын байрны сургалт хийсэн. Сургалтын төгсгөлд сургалтад хамрагдсан ажилтнуудад “Албадлагын арга хэмжээний заавар”-ыг шинэчлэн боловсруулах, Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны эрсдэлийн үнэлгээний сургалтанд хамрагдсан гэрчилгээ олгосон. 3/ <u>TRAINAIR PLUS хөтөлбөрийн хүрээнд:</u> ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төв нь TRAINAIR PLUS хөтөлбөрийн дэмжигч гишүүн байгууллагын статустай бөгөөд 2015 оны 11 дүгээр сард аудитын шалгалт хийж, 2016.01.01-2018.12.31-ний өдөр хүртэл гэрчилгээг сунгасан. Нисэхийн сургалтын төв нь Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албатай хамтран Олон улсын иргэний нисэхийн байгууллагын TRAINAIR PLUS хөтөлбөрийн Нисэхийн мэдээллийн менежментийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын стандартчлагдсан сургалтын багц хөтөлбөр боловсруулж байна. Мөн ИНЕГ-ын төлөөлөгчид TRAINAIR PLUS хөтөлбөрийн 2016 оны нэгдсэн чуулганд амжилттай оролцсон.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	
30.	<p>2.1.1.ИНЕГ-аас боловсруулан гаргаж байгаа баримт бичгийн төсөл хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгааг хянаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Зорилтот түвшин: Батлагдан гарч байгаа баримт бичиг хууль тогтоомжид нийцсэн байна. Хугацаа: 1-12 сар</p>	ХЭЗГ	<p>ИНЕГ-ын үйл ажиллагааны чиглэлээр гарсан 413 тушаал, боловсон хүчний чиглэлээр гарсан 98 тушаал, хөрөнгө оруулалтын 30 гэрээ, бусад төрлийн 64 гэрээг хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгааг хянаж гаргасан байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	27
31.	<p>2.1.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, болон Зам, тээврийн сайд, ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнана. Зорилтот түвшин: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна. Хугацаа: 1-12 сар</p>	ХЭЗГ	<p>Холбогдох эрх зүйн актуудын болон сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийн явцыг тогтоосон хугацаанд гаргаж, ЗТЯ-нд хүргүүлж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	27

32.	<p>2.2.1. Байгууллагын зорилго, стратегийн хэрэгжилтэд саад учруулж болох хамгийн өндөр /стратегийн, үйл ажиллагааны, санхүүгийн болон нийцлийн/ эрсдэлүүдийг бусад нэгжүүдтэй хамтран тодорхойлж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ.</p> <p>Зорилтот түвшин: Аргачлалын дагуу эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн мэдээллийн сантай болсон байна.</p> <p>Хугацаа: 1-6 сар</p>	ХЭЗГ	<p>Байгууллагын зорилго, стратегийн хэрэгжилтэд саад учруулж болох хамгийн өндөр эрсдэлүүдийг бусад нэгжүүдтэй хамтран тодорхойлж их, бага, дунд эрсдэлд ангилан эрсдэлд суурилсан дотоод аудит хийж байна. Төлөвлөгөөний дагуу ИНЕГ-ын харьяа алба, салбар, нэгжүүдэд дотоод аудитын шалгалт хийхдээ тухай бүр эрсдэлийн үнэлгээ хийж байна. Аудит хийх явцад илэрсэн эрсдэл, зөрчил, дутагдлыг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-70%/</i></p>	21
33.	<p>2.2.2. Их, дунд эрсдэлтэй үйл ажиллагаанд дотоод аудит хийх хуваарийг боловсруулан, батлуулж, түүний дагуу аудит хийж, дотоод аудитын зөвлөмж, актын биелэлтийг заасан хугацаанд гүйцэтгэлийн тайлангаар авч, хэрэгжилтэд хяналт тавина.</p> <p>Зорилтот түвшин: Шалгалтын хуваарийг батлуулан, түүний дагуу шалгалтыг бүрэн хийж, тайланг удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулсан байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	ХЭЗГ	<p>ИНЕГ-ын алба, салбаруудад 2016 онд хийх аудитын шалгалтын график төлөвлөгөөг 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр ИНЕГ-ын даргаар батлуулсан. Батлагдсан хуваарийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын нэгж болон түүний харьяа үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагын 3 нэгжид төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 5 нийтдээ 9 аудит шалгалт хийлээ.</p> <p>Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг ИНЕГ-ын даргын тушаалаар баталгаажуулж холбогдох газарт хүргүүлж, тушаал болон зөвлөмжийн биелэлтийг тухай бүр албан бичгээр авч хянаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	27
34.	<p>2.3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ, бусад бодлогын баримт бичиг, Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, салбарын сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын, хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, холбогдох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тогтоосон хугацаанд Зам, тээврийн яаманд хүргүүлнэ.</p> <p>Зорилтот түвшин: Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр удирдлагыг хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Улирал бүр</p>	ХЭЗГ	<p>Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эцсийн тайланг гаргаж 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ, Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж хугацаанд нь тайлагнахаар ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>/хэрэгжилт-90%/</i></p>	27
35.	<p>2.4.1. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авна.</p> <p>Зорилтот түвшин: “Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2016 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p> <p>Хугацаа: 1-12 сар</p>	ЗУГ	<p>ИНЕГ-ын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2016 оны эхний хагас жилийн байдлаар өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 25 сарын, 4 ажилтанд 36 сарын, 1 ажилтанд 12 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг тус тус олгосон. - ИНЕГ, түүний харьяа алба, салбаруудын нийт 3 ажилтанд 	27

